



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 9 сарын 27 өдөр

Дугаар 472

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлж, үнэ шинэчлэн тогтоох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсгийн 2 дахь заалт, 30 дугаар зүйлийн 2, дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Нийслэлийн Татварын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, хавсралтад заасан 25,028,000.00 (хорин таван сая хорин найман мянган) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий, автомашины ашиглах хугацааг сунгаж, үнийг 2,000,000.00 (хоёр сая) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоож, Төв аймгийн Эрдэнэ сум дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Нийслэлийн Татварын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Болдбаатар, Төв аймгийн Эрдэнэ сум дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал Ш.Отгонхүү нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Хөрөнгийг Төв аймгийн Эрдэнэ сум дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх зорилгоор, сургалтын жолооны дадлагын хичээлд ашиглуулахаар хүлээлгэн өгөх.

2.4.Автомашиныг улсын бүртгэл, татварын бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

13-005008
24-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн
472... дүгээр тогтоолын хавсралт



Нийслэлийн Татварын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй
Төв аймгийн Эрдэнэ сум дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн
төвд сургалтын дадлагын жолооны хичээлд ашиглахаар
балансаас балансад шилжүүлэх автомашин

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Гүйлт, км (янга)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)	Цаашид ашиглах хугацаа (жилээр)
1	Соната-FE, 0571 УБЗ, арал№ КМНЕТ41557108	2008/ 2008	915,5	25,028,000.00	2,000,000.00	2
	Нийт дүн			25,028,000.00 (хорин таван сая хорин найман мянган)	2,000,000.00 (хоёр сая)	